## УНТЭ-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь хүний нөөцийн бодлогын болон удирдлагын үйл ажиллагаанд ил тод, нээлттэй зарчмыг баримтлан ажиллаж байна.

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь хүний нөөцийн нээлттэй, ил тод зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажилладаг. УНТЭ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020.06.30-ны өдрийн 11 тоот тогтоолоор “УНТЭ-ийн удирдах ажилтан, ажилтан сонгон шалгаруулах” журмыг батлуулж мөрдөн ажиллаж байна.



УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 06 сарын 30 өдөр Дугаар 11 Улаанбаатар хот

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн
Удирдах ажилтан, ажилтан сонгон
шалгаруулах журам батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10.6 дахь заалт, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Удирдах ажилтан, ажилтан сонгон шалгаруулах журмыг хавсралтаар батласугай.

2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжилтийг ханган ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирал /Т.Мөнхсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.НАРАНТУЯА



Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын 2020 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн 11 дугаар тогтоолын хавсралт

**Улсын нэгдүгээр төв эмнэлгийн**
**Удирдах ажилтан, ажилтан сонгон шалгаруулах журам**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль”, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн “Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн дэд захирал болон нэгжийн удирдлагыг сонгон шалгаруулах” журам, Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын холбогдох заалтуудыг үндэслэн ажилтанг сонгон шалгаруулж, ажилд авах харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү журмын зорилго нь Улсын нэгдүгээр төв эмнэлэгт мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, хандлагатай ажилтанг сонгон шалгаруулж, чадахуйн зарчим /мерит/-ыг хэрэгжүүлэхэд оршино.

**Хоёр. Сонгон шалгаруулахад баримтлах зарчим**

2.1 Сонгон шалгаруулж ажилд авахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

2.1.1 Ил тод байх
2.1.2 Эрх тэгш байх
2.1.3 Шударга ёсыг хангах
2.1.4 Хараат бус байх
2.1.5 Нууцыг чандлан хадгалах
2.1.6 Шударга өрсөлдөөний зарчмыг баримтлах

Зураг 1. ТУЗ-ийн 11 тоот тогтоол нүүр, хавсралт

- УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн алба нь сул ажлын байрыг
  - Эрүүл мэндийн хөгжлийн төвийн - HR.HDC.GOV.MN сайт
  - Монголын ажлын байрны төв сүлжээ - WWW.ZANGIA.MN сайт
  - Эмнэлгийн гадаад цахим вэб хуудас - WWW.UNTE.MOH.GOV.MN сайт
  - Хөдөлмөр халамж үйлчилгээний - WWW.EJOB.GOV.MN сайт
  - Эмнэлгийн гадаад нээлттэй фасебүүк сошиал маркетинг пэйж хуудас “УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ/THE FIRST CENTRAL HOSPITAL OF MONGOLIA”
  - Эмнэлгийн хамт олны хаалттай фасебүүк групп

- Хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг
- Их Дээд сургуулиуд дээр зохион байгуулагддаг өдөрлөг дээр нээлттэй, ил тод зарлаж мэдээллэдэг.

- Мөн Захиргаа, хүний нөөцийн албанд бүртгэгдсэн хүний нөөцийн сангаас бүрдүүлэлт хийж сонгон шалгаруулалтад оролцогчдыг урьж оролцуулдаг.

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь 2023 оны 12-р сарын 30-ны өдрийн байдлаар **22** ажлын байранд 37 удаа сонгон шалгаруулалтын зарыг боловсруулж ил тод, нээлттэй зарлан мэдээллэж ажилласан байна. Үүнд:

Хүснэгт 1.

УНТЭ-ээс зарласан сул ажлын байр, зарын тоон мэдээлэл

| № | Сонгон шалгаруулалт зарласан огноо | Албан тушаал | Сул ажлын байрыг зарласан зарын тоо |
|---|---|---|---|
| 1 | 2023.01.09 | Сувилагч | 1 |
| | 2023.02.14 | | 1 |
| 2 | 2023.01.18 | Үйлчлэгч | 1 |
| | 2023.10.18 | | 1 |
| 3 | 2023.01.31 | Орлогын нягтлан бодогч | 1 |
| | 2023.02.03 | | 1 |
| | 2023.10.31 | | 1 |
| 4 | 2023.01.03 | Халдвар судлаач | 1 |
| 5 | 2023.01.03 | Цахилгааны инженер | 1 |
| | 2023.03.21 | | 1 |
| | 2023.04.11 | | 1 |
| 6 | 2023.04.11 | Цахилгаанчин | 1 |
| 7 | 2023.03.16 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер | 1 |
| | 2023.06.13 | | 1 |
| 8 | 2023.03.02 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан | 1 |
| 9 | 2023.03.02 | Эмзүйч | 1 |
| | 2023.04.17 | | 1 |
| | 2023.10.16 | | 1 |
| 10 | 2023.03.16 | Халаалт, агаар сэлгэлтийн инженер | 1 |
| | 2023.04.11 | | 1 |
| 11 | 2023.04.17 | Хүчилтөрөгчийн ажилтан | 1 |
| 12 | 2023.02.27 | Лабораторийн техникч | 1 |
| | 2023.05.04 | | 1 |
| | 2023.09.26 | | 1 |
| | 2023.10.13 | | 1 |
| 13 | 2023.06.13 | Бүртгэгч, зохион байгуулагч | 1 |
| | 2023.09.04 | | 1 |
| 14 | 2023.06.16 | Анатомийн эмгэг судлаач | 1 |
| 15 | 2023.08.14 | Хөдөлмөр засалч | 1 |
| 16 | 2023.09.08 | Эмийн орлогын нягтлан бодогч | 1 |
| 17 | 2023.09.13 | СБА-ны дарга, ахлах нягтлан бодогч | 1 |
| 18 | 2023.09.14 | Эдийн засагч | 1 |
| 19 | 2023.09.25 | Мужаан | 1 |
| 20 | 2023.10.31 | Чанарын менежер | 1 |
| 21 | 2023.10.31 | Орлогын нягтлан бодогч | 1 |
| 22 | 2023.11.03 | Ахлах касс | 1 |
| 23 | 2023.11.07 | Ахлах сувилагч нар /ЯТТ, СЗЭТ/ | 1 |
| | | Нийт | 37 |

## 1.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН СИСТЕМД

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрүүл мэндийн салбарын нийт ажилчдыг хамарсан сургалт, хөгжлийн хүний нөөцийн систем 2022.03.01-ний өдрөөс эхлэн амжилттай нэвтэрч ажиллаж байна. УНТЭ-ийн хүний нөөцийн менежерүүд нь уг системд тусгай нэвтрэх, нууц үгээр нэвтрэх бөгөөд тус системд сул ажлын байрны зарыг оруулах эрхтэй. 2023.12.30-ны өдрийн байдлаар эмч, эмнэлгийн мэргэжилтэнд хамаарах 6 ажлын байрны зарыг оруулж мэдээллэсэн байна. Үүнд: Сувилагч, халдвар судлаач, эмзүйч, лабораторийн техникч, анатомийн эмгэг судлаач, аөдөлмөр засалч




Хүснэгт 2. УНТЭ-ээс ЭМХТ-ийн hr.hdc.gov.mn хүний нөөцийн сургалт, хөгжлийн системд зарласан сул ажлын байр, зарын мэдээлэл

## 1.2. МОНГОЛЫН АЖЛЫН БАЙРНЫ ТӨВ СҮЛЖЭЭ - WWW.ZANGIA.MN САЙТАНД

Зангиа портал ХХК-тай “Зар сурталчилгааны үйлчилгээ үзүүлэх” мөнгөн гишүүний эрхтэй хэрэглэгчийн хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Гэрээ 2024.09.29 хүртэл сунгагдсан. УНТЭ нь 2023.12.30-ны өдрийн байдлаар Зангиа.мн сайтад 30 ажлын байрны зарыг оруулж ил тод, нээлттэй зарласан.

Уг сайтад зарлагдсан ажлын байрны зарууд нийтдээ 3272 хандалтууд авч, 425 ажил горилогч цахимаар анкетаа илгээсэн үзүүлэлттэй байна.



Зураг 1. Zangia.mn дээр байршуулсан идэвхтэй сул ажлын байрны зарууд

## 1.3. УНТЭ-ИЙН ГАДААД ЦАХИМ ХУУДАС - WWW.UNTE.MOH.GOV.MN САЙТАНД

Байгууллагын гадаад сайтны нээлттэй ажлын байр буланд 2023.12.30-ны өдрийн байдлаар нийт 23 ажлын байрны зарыг ил тод байршуулж мэдээллэсэн.




Зураг 3. www.unte.gov.mn дээр байршуулсан сул ажлын байрны зарууд

## 1.4. ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ - WWW.EJOB.GOV.MN САЙТ

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын мэргэжилтэнтэй 2023.03.14-ний өдөр холбогдон системд ажил олгогч эрхээр бүртгэл үүсгэн ашиглаж байна. 2023.12.30-ны өдрийн байдлаар нийт 12 ажлын байрны зарыг ejob.gov.mn системд бүртгэн ил тод нээлттэй зарласан.



Зураг 4.ejob.gov.mn дээр байршуулсан сул ажлын байрны зарууд

## 1.5. УНТЭ-ИЙН НЭЭЛТТЭЙ ФАСЕБҮҮК СОШИАЛ МАРКЕТИНГ ПЭЙЖ ХУУДАСТ/УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ/THE FIRST CENTRAL HOSPITAL OF MONGOLIA

Эмнэлгийн гадаад нээлттэй фасебүүк сошиал маркетинг пэйж хуудаст 2023.12.30-ны өдрийн байдлаар 23 сул ажлын байрны зарыг нээлттэй, ил тод зарлаж байршуулсан байна.






Зураг 5. Эмнэлгийн гадаад нээлттэй фасебүүк сошиал маркетинг пэйж хуудас дээр байршуулсан сул ажлын байрны зарууд

## 1.6. УНТЭ-ИЙН ЭМНЭЛГИЙН ХАМТ ОЛНЫ ХААЛТТАЙ ФАСЕБҮҮК, ЭМНЭЛГИЙН ДОТООД E-HEALTH СИСТЕМД

Эмнэлгийн хамт олны хаалттай фасебүүк групп, E-health системд 2023.12.30-ны өдрийн байдлаар дотооддоо 4 сул ажлын байрыг нээлттэй, ил тод байршуулж ажилласан. Үүнд: Туслах сувилагч, үйлчлэгч, цахилгаанчин, мужаан



16:48

504 тоот in Улсын Нэгдүгээр Төв

FILTERS | POSTS YOU'VE SEEN | MOST RECENT | POSTED B

**Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн хамт олон**
Lkhagvasuren Oktyabri · Jan 3

УНТЭ-ийн Халдварын сэргийлэлт, хяналтын албанд халдвар судлаачийн сул ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна. Сонгон шалгаруулалтад оролцогчдын материалыг 2023.01.11-ний өдрийн 15.00 цаг хүртэл хугацаанд эмнэлгийн 5-р давхар 504 тоот Захиргаа, хүний нөөцийн албанд хүлээн авна.

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

*"ХҮН ЧАНАРЫГ АЖИЛД АВЧ, УР ЧАДВАРЫГ ЭЗЭМШҮҮЛНЭ"*

**УНТЭ-ИЙН ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН АЛБАНЫ ХАЛДВАР СУДЛААЧ ЭМЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА.**

**Гүйцэтгэх үүрэг:**
- Байгууллагын хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гарах эрсдлээс урьдчилан сэргийлэх, халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих, халдварт өвчин гарсан тохиолдолд хариу арга хэмжээг шуурхай авах, тандалт судалгаа хийх, эрсдэлт хүчин зүйлийг тогтоох, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд тогтмол сургалт, мэдээлэл хүргэх, мэргэжлийн арга зүйн зөвлөмж хүргэх;
- Эмнэлгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа чанар сайжруулах үйл ажиллагаанд оролцох;

**Тавигдах шаардлага:**
- Анагаах ухааны боловсрол олгох их дээд сургуулийг эрүүл ахуйч, тархвар судлаач эмч, нийгмийн эрүүл мэнд судлаач мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн;
- Эрүүл ахуй, халдвар судлал, тархвар судлалын чиглэлээр мэргэшсэн;
- Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан ажлын дадлага туршлагатай байх;
- Дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах ур чадвартай байх;
- Англи болон бусад гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй байх;
- Компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадамжтай;

**Бүрдүүлэх материал:**
- Төрийн албан хаагчийн 1-р маягт /3*4 цээж зураг-1%/
- Их дээд сургууль төгссөн дипломын хуулбар /e-mongolia.mn-ээс/
- Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан бол гэрчилгээний хуулбарууд
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Ажилд орохыг хүссэн өргөдөл

Дээрх шаардлагыг бүрэн хангасан ажил горилогчийн материалыг УНТЭ-ийн Захиргааны 5 давхарт 504 тоот өрөө, Захиргаа, хүний нөөцийн албанд 2023.01.11-ний өдрийн 15.00 цаг хүртэл хугацаанд хүлээн авна. Утас: 77111017

**Сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион явуулна. Үүнд:**
1. Баримт бичгийн шалгаруулалт
2. Ярилцлагын шалгалт



16:48

504 тоот in Улсын Нэгдүгээр Төв

FILTERS | POSTS YOU'VE SEEN | MOST RECENT | POSTED B

**Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн хамт олон**
Lkhagvasuren Oktyabri · Jan 3

УНТЭ-ийн Инженерийн байгууламжийн албанд цахилгааны инженерийн сул ажлын байранд ажилд орохыг урьж байна. Ажил горилогчийн тавигдах шаардлага хангасан материалыг 2023.01.11-ний өдрийн 15.00 цаг хүртэл эмнэлгийн 5-р давхар 504 тоот Захиргаа, хүний нөөцийн албанд хүлээн авна.

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

*"ХҮН ЧАНАРЫГ АЖИЛД АВЧ, УР ЧАДВАРЫГ ЭЗЭМШҮҮЛНЭ"*

**УНТЭ-Т ЦАХИЛГААНЫ ИНЖЕНЕРИЙН СУЛ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛД ОРОХЫГ УРЬЖ БАЙНА.**

**Гүйцэтгэх үүрэг:**
- Эмнэлгийн цахилгаан хангамжийн аюулгүй, хэвийн үйл ажиллагааг хангах;

**Тавигдах шаардлага:**
- Цахилгааны инженер мэргэжлээр их дээд сургуулийг бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй төгссөн;
- Дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах ур чадвартай байх;
- Зөрөг харилцаа, хандлагатай, хорт зуршилгүй байх;
- 3 жилээс дээш ажилласан ажлын туршлагатай;
- Тогтвор суурьшилтай ажиллах;

**Бүрдүүлэх материал:**
- Төрийн албан хаагчийн 1-р маягт /3*4 цээж зураг-2%/
- Боловсролын түвшинг тодорхойлсон бүх баримт бичгүүд /нотариатаар гэрчлүүлсэн байх/
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Ажилд орохыг хүссэн өргөдөл

Дээрх шаардлагыг бүрэн хангасан материалыг УНТЭ-ийн Захиргааны 5 давхарт 504 тоот өрөө, Захиргаа, хүний нөөцийн албанд 2023.01.11-ний өдрийн 15.00 цаг хүртэл хугацаанд хүлээн авна. Утас: 77111017

**Сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион явуулна. Үүнд:**
1. Баримт бичгийн шалгаруулалт
2. Ярилцлагын шалгалт

УНТЭ-ИЙН ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦ АЛБА

Зураг 6. Эмнэлгийн дотоод хаалттай фасебүүк сошиал маркетинг пэйж хуудас дээр байршуулсан сул ажлын байрны зарууд

## 1.7. АНАГААХ УХААНЫ ИХ ДЭЭД СУРГУУЛИУД БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ЯАРМАГ ДЭЭР ОЧИЖ АЖИЛЛАСАН

УНТЭ нь

- ✓ 2023.04.14-ний өдөр Этүгэн их сургууль дээр,
- ✓ 2023.04.21-ний өдөр АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль дээр зохион байгуулагдсан "Ажил олгогчдын нэгдсэн уулзалт"-д амжилттай оролцсон.
- ✓ Мөн УНТЭ нь оюутан сувилагчийн эрүүл мэндийг дэмжин сувилагчийн ажлын байрыг таниулан сурталчлах өдөрлөг зохион байгуулсан








Зураг 7. Оюутан сувилагчийн эрүүл мэндийг дэмжин сувилагчийн ажлын байрыг таниулан сурталчлах өдөрлөг









Зураг 8. Этүгэн их сургууль дээр зохион байгуулагдсан ажил олгогчдын нэгдсэн уулзалтын зураг



Зураг 9. Улаанбаатар хотын АШУҮИС-Сувилахуйн сургууль дээр зохион байгуулагдсан ажил олгогчдын нэгдсэн уулзалт-2023